

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД
2021 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН БАЙДЛААР ИРСЭН ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ
ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон 3 дугаар улирлын өргөдөл гомдлын тайлан мэдээг хүргүүлж байна.

Тайлангийн хугацаанд иргэд аж ахуйн нэгжээс нийт 246 өргөдлийг хүлээн авч бүртгэн хяналтад авсан байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 98,3 хувьтай байна. Шийдвэрлэх хугацаа болоогүй 4 өргөдөл байна.

Нийт ирсэн өргөдлийн 93,9 хувийг нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын чиглэлээр гаргасан хүсэлт, 3,6 хувийг салбарын ажлын талаар ирүүлсэн санал, 2,4 хувийг салбарын ажилтай холбоотой гомдол тус тус эзэлж байна.

Нийт ирсэн 246 өргөдлөөс зонхилж байгаа асуудлыг авч үзвэл газар тариалангийн чиглэлээр хөнгөлөлттэй зээлээр олгож байгаа хүлэмж, хүнсний ногооны үр, трактор, хадлангийн иж бүрдэл бусад техник тоног төхөөрөмж, мах, сүүний чиглэлийн үхэр хүссэн 117, Монгол Улсын гавьяат цол тэмдгээр шагнуулсан хүмүүсийн шагналд олгодог тэтгэмжтэй холбоотой 44, ажилд орох болон ажил, албан тушаалтай холбоотой хүсэлт 19, бусад нь тусгай зөвшөөрөл хүссэн, архиваас мэдээлэл авахыг хүссэн гэх мэт хүсэлтүүд эзэлж байна.

Тайлангийн хугацаанд 6 гомдол ирснийг хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн.

Мөн яамны ажилтнуудаас яамны удирдлагад гаргасан 52 өргөдлийг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэлээ.

2021 оны 3 дугаар улирлын байдлаар иргэд, аж ахуйн нэгжээс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

Хүснэгт 1

Д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт хувь
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
	ХХААХҮЯ	246	242	-	-	4	98.3

2021 оны эхний хагас жилийн байдлаар Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт

Хүснэгт №2

Д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
	ХХААХҮЯ	246	246	-	-	-	-

Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн агуулга /хувиар/

Хүснэгт №3

Д/д	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал тоо, /нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/	
	ХХААХҮЯ	Нийт 246 өргөдлөөс	Хүсэлт 231 /93,9 %/ Санал 9 /3,6 %/ Гомдол 6 /2,4 %/
		Нийт өргөдлөөс зонхилж байгаа асуудлууд	
		<ul style="list-style-type: none"> Салбарын чиглэлээр тусламж дэмжлэг хүссэн 117 /47,5% / Шагнал, шагналыг дагалдах мөнгөн урамшуулал 44 /17,8 % / Ажил албан тушаалтай холбоотой 19 /7,7% / 	

.....оОо.....